

2025 он 08 сар 15 өдөр

Дугаар 25/08

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан
зарлан хуралдуулах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 71 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2025 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 15:00 цагт цахимаар хуралдуулсугай.
2. Саналын хуудасны загварыг нэгдүгээр хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг хоёрдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг гуравдугаар хавсралтаар, Хурлын дэгийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
3. Хурлаар Компанийн оноосон нэрийг “Хөвсгөл” байсныг “Ард Инвестмент Групп” болгон өөрчлөх тухай, Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай, Компанийн хувьцааны бүртгэлтэй байгаа биржийг Монголын Хөрөнгийн Биржээс Улаанбаатар Үнэт Цаасны Бирж болгон өөрчлөх тухай асуудлыг хэлэлцүүлсүгэй.
4. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 9 дүгээр сарын 2-ны өдрөөр тогтоосугай.
5. Хурлын мэдэгдлийг Санхүүгийн Зохицуулах Хороо болон Арилжаа эрхлэх байгууллагад 2025 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлсүгэй.
6. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, өдөр тутмын хоёроос доошгүй сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2025 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн дотор нийтэд зарласугай. Давтан зарыг 2025 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, зэрэг бусад холбоотой баримт бичгийг бэлэн болгож 2025 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн дотор үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.
8. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2025 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 17:00 цагаар тасалбар болгосугай.

9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Хурал зохион байгуулах комиссын дарга:

“Хөвсгөл” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг

Хурал зохион байгуулах комиссын гишүүд:

“Хөвсгөл” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Э.Халиунгоо

10. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Тооллогын комиссын дарга:

‘ Ард секюритиз ҮЦК’ ХХК-ийн хуулийн зөвлөх Ө.Бямбагэрэл


Тооллогын комиссын гишүүд:

‘ Ард секюритиз ҮЦК’ ХХК-ийн дилер Ч.Даваацэрэн

‘ Ард секюритиз ҮЦК’ ХХК-ийн Хөрөнгө оруулалтын зөвлөх
А.Эрхбилгүүн

11. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хурлыг зарлан хуралдуулж, хурлын зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолыг бүрэн дүүрэн, түргэн шуурхай гүйцэтгэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.

12. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн шийдвэр болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Э.Халиунгоо-д даалгасугай.

ДАРГА  П.БАТБАЯР



Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2025 оны 08 сарын 13-ны өдрийн
25/08 тоот тогтоолын 1-р хавсралт

САНАЛ ХУРААЛТЫН ХУУДАС
/ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 1,2/



Хувьцаа эзэмшигчдийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Энэхүү санал авах хуудсаар 2025 оны 09 сарын 22-ны өдрийн 15:00 цагт хуралдах “Хөвсгөл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн оноосон нэрийг “Хөвсгөл” байсныг “Ард Инвестмент Групп” болгон өөрчлөх тухай			
2	Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай			
3	Компанийн хувьцааны бүртгэлтэй байгаа биржийг Монголын Хөрөнгийн Биржээс Улаанбаатар Үнэт Цаасны Бирж болгон өөрчлөх тухай			

1. Та саналын хуудсыг бөглөхдөө ✓ тэмдгийг бичнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Ард Секюритиз Үнэт цаасны компани (ҮЦК) дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар урьдчилан саналаа өгөөрэй.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____

Санал авах хуудсыг үйлдсэн 2025 оны ...: сарын өдөр

Санал авах хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй

Тооллогын комиссын дарга _____ /

Хүчингүйд тооцсон бол шалтгаан: _____

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2025 оны 08 сарын 13-ны өдрийн
25/08 тоот тогтоолын 2-р хавсралт

“ХӨВСГӨЛ” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Хөвсгөл” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 25/08 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлаж байна.

ХУРАЛ ХУРАЛДАХ ГАЗАР: “Ард” аппликэйшнээр дамжуулан цахим хэлбэрээр

ХУРАЛ ХУРАЛДАХ ӨДӨР, ЦАГ: 2025 оны 09 дүгээр сарын 22, 15:00 цаг

КОМПАНИЙН НЭР: “Хөвсгөл” ХК

ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Компанийн оноосон нэрийг “Хөвсгөл” байсныг “Ард Инвестмент Групп” болгон өөрчлөх тухай;
2. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай;
3. Компанийн хувьцааны бүртгэлтэй байгаа биржийг Монголын Хөрөнгийн Биржээс Улаанбаатар Үнэт Цаасны Бирж болгон өөрчлөх тухай

БҮРТГЭЛИЙН ӨДӨР: 2025 оны 09 дүгээр сарын 2-ны өдөр

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоолын төслүүд;
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын дэг;
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудас;
4. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга;
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын материал

Хувьцаа эзэмшигч та ажлын өдрүүдэд **09:00-18:00** цагийн хооронд доорх газруудад хандаж хурлын материал, саналын хуудастай танилцах боломжтой.

- Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай-2, Централ Тауэр, 17 давхар;
- Имэйл хаяг: info@huvsgul.co
- Утас: 99912707, 77003322

Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцох боломжгүй бол “Ард Секюритиз” ҮЦК ХХК-д очиж саналын хуудсаар урьдчилан саналаа өгөх эсхүл Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай-2, Централ Тауэр, 17 давхар хаягаар “Хөвсгөл” ХК-д шуудангаар явуулах боломжтой. Саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа 2025 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 17:00 цаг байна.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2025 оны 08 сарын 13-ны өдрийн
25/08 тоот тогтоолын 3-р хавсралт

ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоолын төслүүд;
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын дэг;
8. Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудас;
9. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга;
10. Хувьцаа эзэмшигчдийн хурлын материал

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ДЭГ

№	Хуваарь	Хариуцах тал	Цаг
1	Хурлын ирцийг бүртгэх, мэдээлэх	Тооллогын комисс	15:00-15:15
2	Хурлын дарга хурлыг нээж, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	Хурлын дарга	15:15-15:35
3	Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах, санал авах 1. Компанийн оноосон нэрийг “Хөвсгөл” байсныг “Ард Инвестмент Групп” болгон өөрчлөх тухай; 2. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай; 3. Компанийн хувьцааны бүртгэлтэй байгаа биржийг Монголын Хоронгийн Биржээс Улаанбаатар Үнэт Цаасны Бирж болгон өөрчлөх тухай	Хурлын дарга	15:35-16:10
4	Хэлэлцэх асуудал тус бүрээр санал хураалт явуулах	Тооллогын комисс	16:10-16:25
5	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах		16:25-16:35
6	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	Хурлын дарга	16:35-16:55
7	Хурлыг хаах		17:00